

ХУРЛЫН МЭДЭЭЛЭЛ

Хурлын тов: 2026 оны 4 сарын 27-ний өдрийн 10:00 цагт

Хурал болох байр: Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18235 товчооны зам гудамж, 59 тоотод байрлах өөрийн байранд болно.

ХАЙ БИ ОЙЛ ХК-ИЙН ХУВЬЦАА ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ

1	Хурлын ирцийг бүртгэх /ажлын хэсэг/	10:00-10:15
2	Хурлын ирцийг мэдээлэх /ажлын хэсэг/	5 минут
3	Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах	15 минут
4	Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, асуулт хариулт, саналын хуудас бөглөх, санал хураалт	60 минут
5	Хурлын завсарлага	10 минут
6	Тооллогын комиссын тогтоолыг танилцуулах	10 минут
7	Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах	10 минут
8	Хурлыг хаах / хурлын дарга/	10 минут

ХУРЛААР ХЭЛЭЛЦЭХ АСУУДЛУУД

- a. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
- b. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
- c. Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийн танилцуулга



“ХАЙ БИ ОЙЛ” ХК – ИЙН ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ

2026 оны 03 сарын 18 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал хуралдуулах тухай

Монгол Улсын Компанийн тухай хуулийн 59, 60 дугаар зүйл, Санхүүгийн зохицуулах хорооны “Хувьцаат компанийн хувьцаа эзэмшигчдийн хурлын зар хүргэх журам” болон “Хай Би Ойл” ХК-ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн гишүүдийн саналыг тус тус үндэслэн **ТОГТООХ НЬ:**

1. “Хай Би Ойл” ХК-ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 4 дүгээр сарын 27-ний өдрийн Даваа гаргийн 10:00 цагт Улаанбаатар хот, Сонгинохайрхан дүүрэг, 20-р хороо, 18135 товчооны зам гудамж, 59 тоот хаягт байрлах өөрийн байранд зарлан хуралдуулсугай.
2. “Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай:
 - а. Компанийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ТУЗ-ийн гаргасан дүгнэлтийг хэлэлцэн батлах
 - б. ТУЗ-ийн ердийн болон хараат бус гишүүдийг сонгох
 - с. Ногдол ашгийн талаар гаргасан шийдвэрийн танилцуулга
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах Бүртгэлийн өдрийг 2026 оны 04 дугаар сарын 07-ний өдрөөр тогтоосугай.
4. Компанийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын зарыг Хавсралт №1-ийн дагуу баталж, нийтэд мэдээлэх өдрийг ТУЗ-ын шийдвэр гарснаас хойш 5 дахь өдөр буюу 2026 оны 03 дугаар сарын 23-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар болон өдөр тутмын 2-оос доошгүй сониноор мэдээлэх, хурлын зар мэдээг мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа буюу 2026 оны 04 сарын 07-ны өдөр анх мэдээлсэн хэлбэрийн дагуу дахин мэдээлэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
5. Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг Хавсралт №2-оор баталсугай.
6. Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар хэлэлцэх асуудалтай холбогдсон хувьцаа эзэмшигчдийн танилцаж болох бичиг баримтын жагсаалтыг Хавсралт №3-аар баталсугай. Хавсралт №3-т заасан бичиг баримттай ажлын өдрүүдэд 09⁰⁰-17⁰⁰ цагийн хооронд Улаанбаатар, Сүхбаатар дүүрэг, 2-р хороо, Twin Tower -1 оффисын 10-р давхар, 1002 тоотод ирж танилцах боломжтойг дурдсугай.

7. Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах “Саналын хуудас”-ын агуулгыг Хавсралт №4-ийн дагуу баталсугай.
8. Үнэт цаасны компаниар дамжуулан хувьцаа эзэмшигчдээс “Санал авах хуудас”-ыг хүлээн авах сүүлийн өдрийг хурал хуралдах өдөр буюу 2026 оны 04 сарын 27-ний 10:00 цаг хүртэл байхаар тогтоосугай.
9. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын даргаар Гүйцэтгэх захирал Ш.Амар-отгон, хурал зохион байгуулах комиссын даргаар Ш.Амар-Отгон, гишүүнээр Н.Батнайрамдал, О.Ганчимэг Тооллогын комиссын даргаар Ш.Амарсайхан, гишүүдээр Л.Даваагэрэл, Б.Гэрэлтуяа нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Б.ДӨЛГӨӨНТАМИР

“Хай Би Ойл” ХК-ийн 2025 оны үйл ажиллагааны болон санхүүгийн тайлангийн талаарх ажлын тайлан, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн дүгнэлт

- ❖ Нэр: “Хай Би Ойл” ХК
- ❖ Хаяг: Улаанбаатар хот, СХД, 20-р хороо, Сонсголонгийн /18135/ товчооны зам 59 тоот
- ❖ Утас: 88119740, 99904034
- ❖ Улсын бүртгэлийн дугаар: 9010001063
- ❖ Регистрын дугаар: 2615134
- ❖ Үйл ажиллагааны чиглэл: Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, тээвэрлэх, дахин боловсруулах, Тусгай зөвшөөрлийн бүртгэлийн дугаар: 000053
- ❖ Үнэт цаасны нийт тоо ширхэг: 52,118,954 ширхэг

Удирдлагын талаарх мэдээлэл:

Хай Би Ойл ХК-ийн 2025.04.25-ны өдрийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар Төлөөлөн удирдах зөвлөлийн ердийн гишүүдээр У.Энхбилэг, Ш.Амар-Отгон, Б.Батбаатар, С.Одгэрэл, Р.Оюунбат, Б.Дөлгөөнтамир нар, хараат бус гишүүдээр Г.Бадамдорж, Т.Тамир, Б.Гэрэлтуяа нар сонгогдож, Төлөөлөн удирдах зөвлөлийн даргаар Б.Дөлгөөнтамир, Гүйцэтгэх захирлаар Ш.Амар-отгон, ТУЗ-ийн нарийн бичгээр Н.Батнайрамдал нар сонгогдон ажилласан.

Төлөөлөн удирдах зөвлөлийн дарга, гишүүд, нарийн бичгийн дарга, гүйцэтгэх захирал нар 100 хувь компанийн засаглалын сургалтад хамрагдсан.

I. Үйл ажиллагааны тусгай зөвшөөрөл: Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яамнаас олгодог “Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэх” тусгай зөвшөөрлийн хугацаа дууссан тул 2025 оны 4 дүгээр сард холбогдох материалыг бүрдүүлэн хүргүүлсэн. Үүний үр дүнд тусгай зөвшөөрлийг 2025 оны 8 дугаар сарын 1-ний өдрөөс эхлэн 10 жилийн хугацаагаар сунгуулсан.

**АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, УСТГАХ ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ**

Дугаар 0000053 Огноо: 2025.08.01

Хавсралт 1 -д заасан нөхцлийн дагуу аюултай хог хаягдал
Техникийн хаягдал тосыг тээвэрлэх, цуглуулах,
хадгалах, дахин боловсруулах үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг
(зөвшөөрлийн төрөл)
9010001063 улсын бүртгэлийн дугаартай 2815134
регистрийн дугаартай “Хай би ойл” ХК -д 2025 оны 07 дугаар сарын 31 -ны
өдрөөс 2035 оны 07 дугаар сарын 31 -ны өдөр 10 жилийн хугацаагаар олгов.

Үйл ажиллагаа эрхлэх талаарх мэдээлэл:
Аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа
эрхлэгчийн бүртгэлийн дугаар 000080
Аж ахуйн нэгж/иргэний хаяг: Улаанбаатар аймаг, хот Сонгинохайрхан
сум, дүүргийн 20 дугаар баг, хорооны товчооны зам гудамж, 59 тоот
(судамж, байшин/хувцасны дугаар)
Зөвшөөрөл олгосон үйл ажиллагаа явуулах газрын байршил: Улаанбаатар
аймаг, хот Сонгинохайрхан сум, дүүргийн 20 дугаар
баг, хорооны Үйлдвэрлэл нүүрсний газрын урд
(газрын нэр/судамж/хотын нэр, дугаар)

Хавсралт нь энэхүү зөвшөөрлийн салшгүй нэг хэсэг болно.

Зөвшөөрөл олгосон:

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД
(байгууллагын нэр, албан тушаал)



Б.БАТБААТАР
(овог нэр)

2025 оны 08 сарын 01 өдрийн

0000053 зөвшөөрлийн

01 хавсралт

№	Тушаалын дугаар	Хугацаа	Олгосон өдөр
1	A/659	2025.07.31-2035.07.31	2025.08.01
2			
3			
4			
5			

БАЙГАЛЬ ОРЧИН, УУР
АМЬСГАЛЫН ӨӨРЧЛӨЛТИЙН
САЙД

(байгууллагын нэр, албан тушаал)

(гарын үсэг, тамга)

Б.БАТБААТАР

(овог нэр)

САНАМЖ:

Тус яамнаас олгосон энэхүү гэрчилгээг зориулалтын бусаар ашигласан, үйл ажиллагаандаа ноцтой алдаа дутагдал гаргасан, худалдан борлуулсан, холбогдох хууль тогтоомжийг зөрчсөн бол хүчингүй болгох үндэслэл болно.

Зураг1. Тусгай зөвшөөрөл

Байгаль орчин, уур амьсгалын өөрчлөлтийн яам болон Монгол Улсын Шинжлэх ухааны академийн Хими, химийн технологийн хүрээлэнгээс зохион байгуулсан сургалтад ажилтнуудыг хамруулсан. Тус сургалтын хүрээнд аюултай хог хаягдлын менежментийн олон улсын туршлага болон Базелийн конвенцод нийцсэн хог хаягдлын тооллого хийх аргачлалын талаар мэдлэг олгосон.



Зураг 3. Сургалт

4. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөөний биелэлт

Тос буулгах хэсгийг бетонжуулж, хөрсний бохирдсон хэсгийг саармагжуулах ажлыг гүйцэтгэсэн. Мөн агаарт үүсэх тоосжилтыг бууруулах, хөрсийг хамгаалах зорилгоор агуулахын талбайг хатуу хучилттай болгож тохижуулсан.



Зураг 4. Хөрс бетонжуулалт

Үйлдвэр, түүхий эд цуглуулах болон хадгалах агуулах, үйлдвэрийн байр, оффис, газар доорх байгууламжууд, нүхэн жорлон зэрэг талбайн хөрсийг хамгаалах арга хэмжээ авч хэрэгжүүлсэн. Үүнд хаягдал тос буулгах цэгийн бохирдсон хөрсийг бетонжуулж, 8 ширхэг Nowo автомашинаар нийт 144 м³ шороо асган саармагжуулалтын ажлыг гүйцэтгэсэн.





Зураг 5. Хөрс саармагжуулалт

Үйлдвэр доторх агаарын чанарт үзүүлэх нөлөөллийг бууруулах газрын гадаргаас тоос тоосонцор агаарт дэгдэх магадлал өндөр, тоосжилтыг дарах, үйлдвэрийн зохион байгуулалтыг сайжруулахын тулд тоног төхөөрөмжний шугам хоолой, нацосыг засаж сайжруулсан.



Зураг 6. Үйлдвэрийн тоног төхөөрөмжний засвар үйлчилгээ

✓ Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах

Технологит ашигласан бохир усыг ил задгай зайлуулахгүй байх, хөрсөнд алдагдахаас сэргийлэхийн тулд дахин цэвэршүүлэх тоног төхөөрөмжийг захиалан авсан байна. 2026 оны 2-аар улиралд үйлдвэрийн тоног төхөөрөмжиндөө холбон ашиглалтанд оруулна.



Зураг 7. Саарал усны цэвэршүүлэгч тоног төхөөрөмж

Улаанбаатар Цахилгаан түгээх сүлжээ хувьцаат компаниас электрон тоолуур солиж, цахилгааны тоолуурын баталгаажуулалтын гэрчилгээ, электрон тоолуур тавих зөвшөөрлийн гэрчилгээ авсан.

 СТАНДАРТ,
ХЭМЖИЛ ЗҮЙН
ГАЗАР

**ЦАХИЛГААН ТООЛУУРЫН
БАТАЛГААЖУУЛАЛТЫН ГЭРЧИЛГЭЭ**
№ ЦТ **946867**.....

.....-Д
(хэрэглэгчийн нэр)
ашиглаж байгаа DTSD545S загварын
3 фазын № 24131788 -ын
механик, электрон, тарифт электрон тоолуурыг № 011 лацаар
(доогуур зурах)
битүүмжилж 2023 оны 10 -р сарын 14 -ны өдөр хүртэл улсын
баталгаажуулалтын гэрчилгээ олгов.

Шалгалтын дараах заалт: 0.0 кВт ц

Лабораторийн тэмдэг Улсын шалгагчийн
2025 10 14 гарын үсэг, тэмдэг
..... оны -р сарын -ны өдөр

 **УЛААНБААТАР ЦАХИЛГААН ТҮГЭЭХ СҮЛЖЭЭ
ХУВЬЦААТ КОМПАНИ**
**ЭЛЕКТРОН ТООЛУУР ТАВИХ
ЗӨВШӨӨРӨЛ № . 0780311**

Хэрэглэгчийн нэр _____
Хаяг _____
Регистрийн дугаар _____
3 фазын DTSD545S маркын 24131788 номерын
электрон тоолуурыг 3 тарифаар программчилж
(программыг шалгаж) хэлхээнд тавихыг зөвшөөрөв.
Энэхүү зөвшөөрлийн бичиг СХГ-ын гэрчилгээний хамт, баталгаажуулалтын
хугацаанд хүчин төгөлдөр.

Зөвшөөрсөн Инженер _____ /
2025 он 10 сар 14 өдөр
Хуулбарлан ашиглахыг хориглоно.

Зураг 8. Электрон тоолуурын зөвшөөрөл

5.Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөөний биелэлт

Нийслэлийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй авто засварын газруудаас техникийн ашигласан хаягдал тос тээвэрлэх зориулалтын автомашинд хот дотор зорчих ЕС зөвшөөрлийн сунгалтыг хийлгэж, 6 сарын хугацаатай түр зөвшөөрөл авсан.

Мөн ажилчдын унаа (Prado, Starex) болон тос тээвэрлэх автоцистернүүд (Kia Rhino)-д ээлжит засвар үйлчилгээ хийж, тээврийн хэрэгслийн татвар, улсын үзлэг, оношилгоо, даатгалд бүрэн хамруулсан.

Техникийн ашигласан хаягдал тос цуглуулж, тээвэрлэдэг зориулалтын автоцистерн 6027УНП, 8408УНЗ автомашинуудад Нийслэлийн онцгой байдлын газраас Галын аюулгүй байдлын дүгнэлт гаргуулсан.


Зураг 9. Тээврийн хэрэгслийн ЕС зөвшөөрөл



Зураг 10. Тээврийн хэрэгслийн галын аюулгүй байдлын дүгнэлт

✓ Ажилчдын эрүүл мэндийн үзлэг

Манай компани нь УБ Сонгдо эмнэлэгтэй эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг болон багц шинжилгээ хийлгэх гэрээ байгуулж нийт ажилчдаа 2025 оны 10-р сарын сүүлийн долоо хоногт эрүүл мэндийн үзлэг шинжилгээнд хамруулахаар болсон.



УБ СОНГДО ЭМНЭЛЭГ
UB SONGDO HOSPITAL
Bumrungrad Health Network

Standard Health-Үндсэн шинжилгээ


<p>Цусны бүлэг ABO Цусны бүлэг Rho(D) Резус фактор</p> <p>Цусны бүлэгнэлтийн шинжилгээ APTT (Activated Partial Thromboplastin Time) PT (Prothrombin Time) Fibrinogen</p> <p>Цусны ерөнхий шинжилгээ CBC Routine Цусны ерөнхий шинжилгээ ESR (Erythrocyte) Эритроцитийн тунах хурд Fe (Iron) Төмөр</p> <p>Нойр булчирхайн шинжилгээ Amylase (Total) Нойр булчирхайн фермент</p> <p>Элэгний үйл ажиллагаа AST (SGOT) АСАТ ALT(SGPT) АЛАТ T.Protein Нийт уураг Albumin Альбумин T.bilirubin Нийт Билирубин D.bilirubin Шууд Билирубин Gamma-GPT ГГТ ALP Шүлтлэг фосфатаз</p> <p>Элэгний вирусн маркер HBsAg В вирусн эсрэг төрөгч Anti-HBs В вирусн эсрэг бие Anti-HCV Элэгний С вирус</p> <p>Боорний үйл ажиллагаа BUN Үлдэгдэл азот Creatinine Креатинин Uric acid Шээсний хүчил</p> <p>Өөх тосны үзүүлэлт T.Cholesterol Нийт Холестерин HDL-Cholesterol Их нягттай липопротеид LDL-Cholesterol Бага нягттай липопротеид Triglyceride Триглицерид LDH Лактатдегидрогеназа /ЛДГ/ CPK Лактатдегидрогеназа</p> <p>Цусан дахь сахар Glucose Глюкоз</p>	<p>Бамбай булчирхайн үйл ажиллагаа T3 Total-Triod Триодтиронин Free T4 (CLIA) Чөлөөт тироксин TSH Тириод сэдээгч даавар</p> <p>БЗХӨ Anti-HIV(Rapid) ДОХ Syphilis TRHA Тэмбүү</p> <p>Хавдрын маркерийн шинжилгээ PSA Түрүү булчирхайн хавдрын маркер CA125 Өндгөвчний хавдрын маркер</p> <p>Үе мочний шинжилгээ RA Factor Ревматоид фактор CRP С-урвалжит уураг</p> <p>Шээсний ерөнхий шинжилгээ Urine test Шээсний шинжилгээ</p> <p>Хелико бактерийн шинжилгээ Helicobacter(urease) Хелико бактер(үлээдэг)</p> <p>Дурангийн шинжилгээ Gastro Duodenoscopy Ходоодны дуран Colonoscopy Бүдүүн шулүүн гэдэсний дуран /цэвэрлэх эм</p> <p>ЭХО шинжилгээ Sono (Thyroid) Бамбайн эхо Sono (Upper abdomen+Pelvice) Хэвлий,аарцагны эхо /түрүү булчирхай/</p> <p>Рентген зураг Chest PA Цээжний рентген</p> <p>Эмэгтэйчүүдийн шинжилгээ PAP Умайн хүзүүний хорт хавдрын эсийн шинжилгээ</p> <p>Аппаратын шинжилгээ EKG Зүрхний цахилгаан бичлэг Hearing test Сонсгол Eye test Нүдний уг,даралт,хараа шалгах PFT (Flow Volume) Уушигны багтаамж BMI Биеийн жингийн индекс Blood pressure Артерийн даралт</p> <p>Эмчийн зөвлөгөө Doctor's consultation Эмчийн зөвлөгөө</p>
--	--

7575-2727 1,038,000₮ WWW.SONGDO.MN

Зураг 11. Ажилчдын эрүүл мэндийн үзлэг

6. Орчны хяналт шинжилгээний менежментийн тоглогөөний биелэлт

Байгаль орчны төлөв байдлын судалгааны ажлын хүрээнд төслийн талбайгаас худгийн ус, бохир ус, агаар, хөрсний бохирдлын түвшинг тодорхойлох зорилгоор дээж авч “Байгаль орчин хэмжилзүйн төв лаборатори” ХХК-ийн хөрс судлалын лабораторид шинжлүүлэв.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2025/ Ц-88
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: “Хай Би Ойл” ХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Л.Даваагэрэл
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2025.06.18
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	MNS 6836:2020, MNS 6833:2020 MNS 1097:2023, MNS 6779:2019 MNS 6834:2020, MNS ISO 6878:2001 MNS 4430:2005, MNS 6272: 2011
Шинжилсэн огноо	: 2025.06.18-2025.06.31
Хуудасны тоо	: 1 / 2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	Ж/Б мг/л	ПИЧ мг/л	NH ₄ мг/л	NO ₂ мг/л	NO ₃ мг/л	PO ₄ мг/л	Fe мг/л	F мг/л
СХД, 20-р хороо “Хай Би Ойл” ХК Үйлдвэрийн хашааны худаг	3.2	0.8	0.77	0.043	37.57	0.007	0.06	0.15
MNS 0900:2018	-	-	1.5	1.0	50	3.5	0.3	0.7-1.5

Тайлбар: Ж/Б-Женгэдэгч бодис, ПИЧ-Перманганатын Исагдах Чанар.

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:




Б.Анужин

Ц.Мийдүв

Б.Аптантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№	: 2025/ Ц-88
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас	: "Хай Би Ойл" ХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал	: Л.Даваагэрэл
Сорьцын тоо, төрөл	: 1, ус
Сорьц авсан огноо	: 2025.06.18
Сорьцын тодорхойлолт	: Худгийн ус
Шинжилгээний аргын стандарт	MNS ISO 10523:2001, MNS ISO 7888:1999 MNS 1097:2023, MNS 4424:2005 MNS 6832:2020
Шинжилсэн огноо	: 2025.06.18-2025.06.31
Хуудасны тоо	: 2 /2
Үр дүн	: 1

Сорьц авсан цэг	pH	EC мкСи/см	SO ₄ мг/л	Cl мг/л	Ca мг/л	Mg мг/л	Na+K мг/л	HCO ₃ мг/л	Эрд мг/л	Хат мг-экв/л
СХД, 20-р хороо "Хай Би Ойл" ХК Үйлдвэрийн хашааны худаг	6.97	988	156	83.3	102	15.6	42.8	151	551	6.37
MNS 0900:2018	6.5-8.5	1000	500	350	100	30	-	-	-	7.0

Тайлбар: EC - цахилгаан дамжуулах чанар, Хат-Хатуулаг, Эрд-Эрдэжилт

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч:

Шалгасан шинжээч:

Хянаж баталгаажуулсан ахлах шинжээч:



Б.Анужин

Ц.Мийдүв

Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцод хүчинтэй.

Зураг 12. Худгийн ус шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohzt1@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/422-425
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хай Би Ойл" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 4 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2025.07.29
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар - СХД 20-р хороо
Шинжилгээний аргын стандарт : САЗ А01:2022
Шинжилсэн огноо : 2025.08.05
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	Кадьми (Cd)	Хар тугалга (Pb)	Мөнгөн ус (Hg)	Хром (Cr)	Цайр (Zn)	Зэс (Cu)	Стронци (Sr)
		мг/кг						
1	Оффисын зүүн талаас	<0.05	19	<0.005	<0.5	123	28	613
2	Газар савны баруун талаас	<0.05	16	<0.005	<0.5	110	28	422
3	Худгийн хойд талаас	<0.05	9	<0.005	<0.5	<0.5	26	363
4	Үйлдвэрийн баруун талаас	<0.05	16	<0.005	<0.5	11	25	630
MNS 5850:2019/ ЗДХ/		3	100	2	150	300	100	800

Шинжилгээ гүйцэтгэсэн:

Д. Даваасүрэн

Ахлах шинжээч Б.Даваасүрэн


Хянаж баталгаажуулсан:

В. Алтантуяа

Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.

Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН ХЭМЖИЛ ЗҮЙН ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж, Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Улаанбаатар хот
Утас: 11-341818 И-мэйл: bohztll@gmail.com



СОРИЛТЫН ДҮН

Дугаар он/№ : 2025/422-425
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хай Би Ойл" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 4 хөрсний сорьц
Сорьц авсан огноо : 2025.07.29
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар - СХД 20-р хороо
Шинжилгээний аргын стандарт : MNS 3310:1991
Шинжилсэн огноо : 2025.08.12
Хуудасны тоо : 1/1
Үр дүн

№	Сорьц авсан цэгийн нэр	pH	Ялзмаг %	Аммоний азот (NH ₄ -N) мг/кг	Нитратын азот (NO ₃ -N) мг/кг	Фосфор (P ₂ O ₅) мг/кг	Сульфат (SO ₄) мг/кг
1	Оффисын зүүн талаас	8.06	1.0	52.1	0.4	21.5	53.5
2	Газар савны баруун талаас	8.30	0.6	37.4	1.5	11.8	26.1
3	Худгийн хойд талаас	8.29	0.7	34.5	13.0	14.5	248.9
4	Үйлдвэрийн баруун талаас	8.67	0.6	37.4	1.0	19.3	133.1

Шинжилгээ гүйцэтгэсэн:

У.Төгсрчим

Шинжээч У.Болорчимэг


Хянаж баталгаажуулсан:

Б.Алтантуяа

Ахлах шинжээч Б.Алтантуяа

Хуулбарлан хэрэглэхийг хориглоно.
Сорилтын дүн нь зөвхөн шинжилсэн сорьцонд хүчинтэй.

Зураг 14. Хөрсний шинжилгээ



ЦАГ УУР, ОРЧНЫ ШИНЖИЛГЭЭНИЙ ГАЗАР
БАЙГАЛЬ ОРЧИН, ХЭМЖИЛ ЗҮЙН
ТӨВ ЛАБОРАТОРИ

17043, Үйлдвэр 2-4, Чингисийн өргөн чөлөө гудамж,
Хан-Уул дүүрэг, 20-р хороо, Утас: 11-341818
E-mail: bohzt@gmail.com

СОРИЛТЫН ДҮН



Дугаар он/№ : 2025/A-660-661
Сорьц ирүүлсэн газрын нэр, хаяг, утас : "Хай Би Ойл" ХХК
Сорьц авсан хүний нэр, албан тушаал : Д.Сувд агаарын хэсэг
Сорьцын тоо, төрөл : 2 агаар, 2 дуу чимээ
Сорьц авсан огноо : 2025.07.29
Сорьцын тодорхойлолт : Улаанбаатар хот СХД 20-р хороо
Шинжилгээний аргын стандарт : MNS 17-2-5-12:2021, MNS 17-2-5-11:2021
MNS 6768:2019, CA3 A07-2016
Шинжилсэн огноо : 2025.08.05
Хуудасны тоо : 1/1
Үр дүн :

№	Сорьц авсан цэг	Сорьц авсан өдөр	Сорьц авсан цаг	Хүхэрлэг хий	Азотын давхар исэл	Нийт тоос /TSP/	Дуу чимээ
					мкг/м ³		
1	Үйлдвэрийн гадна талбай	25/07/29	12:25	15	65	197	58
Агаарын чанарын стандарт MNS 4585:2025 (20 минутын хэмжилт)				450	200	500	60
2	Үйлдвэрийн хэсэг дотор	25/07/29	13:09	19	121	287	64
Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Ажлын байрны орчин.Эрүүл ахуйн шаардлага MNS 4990:2023				2000	2000	10000	-
Хөдөлмөрийн аюулгүй байдал,эрүүл мэнд.Шуугианы норм.Аюулгүй ажиллагааны ерөнхий шаардлага MNS 6768:2019							85

Шинжилгээ гүйцэтгэсэн шинжээч :

Хянаж баталгаажуулсан:
Байгаль орчны шинжилгээний хэлтсийн дарга

Э.Оюунтуяа
Б.Бархасрагчаа

Зураг 15. Агаар, дуу чимээний шинжилгээ

7. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө

Ахуйн хог хаягдлыг ангилан ялгаж, дүүргийн ТҮК-тэй гэрээ байгуулан тогтмол тээвэрлүүлж байна. Ажилчдын ахуйн хэрэглээнээс үүсэх хог хаягдалд хоолны үлдэгдэл, цаас, хайрцаг, сав баглаа боодол зэрэг багтана.

Нийт 8 ажилтан жилд дунджаар 140 хоног ажиллахад өдөрт 4 кг, сард 120 кг, жилд ойролцоогоор 840кг хатуу хог хаягдал үүсэх тооцоо гарсан. Үйлдвэрээс гарах саарал усыг 3 дамжлагат тунгаах системээр цэвэршүүлсний дараа хөргөлтийн системд дахин ашиглаж байна.



Зураг 16. Ахуйн хог хаягдал



ХОГ ХАЯГДЛЫН ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ХУРААМЖИЙГ ХУРААХ, ТЭЭВЭРЛЭХ ГЭРЭЭ

НЭГ. ГЭРЭЭНИЙ ЗОРИЛГО

2.1 Засаг даргатай байгуулсан гэрээний дагуу дүүргийн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж байгаа аж ахуй нэгж, төсөвт болон төрийн бус байгууллагуудын ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг цуглуулж ачих, тээвэрлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд энэхүү гэрээний зорилго оршино.

ХОЁР. ГЭРЭЭНИЙ ҮНДЭСЛЭЛ

2.1 Монгол улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.10, 2017 оны 05 дугаар сарын 12-ны өдрийн шинэчилсэн найруулга Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйл, 10 дугаар зүйл, 14 дүгээр зүйлийн 14.2, 41 дүгээр зүйлийн 41.1, 41.3, 41.5, 41.8, 43 дугаар зүйл, Татварын ерөнхий хуулийн 7 дугаар зүйлийн 7.2.23, Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн баталсан "Хог тээвэрлэгчийг сонгон шалгаруулах, санхүүжүүлэх, үйлчилгээний хураамжийг төвлөрүүлэхэд мөрдөх журам", Сонгинохайрхан дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01-р тогтоолыг үндэслэн дор дурдсан нөхцөлүүдийг харилцан тохиролцож байгуулав.

2.2 Энэхүү гэрээг 2615134

НЭГ ТАЛААС: Сонгинохайрхан дүүргийн татварын хэлтэс /цаашид татварын байцаагч гэх / Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын дэргэдэх "Тохижилт цэвэрлэгээ үйлчилгээний төв" ОНӨААТҮГ /цаашид тээвэрлэгч гэх/с
НӨГӨӨ ТАЛААС:
Дан Ой Ойи ХХ иргэн, аж ахуй нэгж, албан байгууллага /доогуур зурах/
Данш бондосруулах үндэвч үйл ажиллагааны чиглэлтэй /цаашид үйлчлүүлэгч гэх/ нар харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

ГУРАВ. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА

3.1 2025 оны 01 -р сарын 01-ны өдрөөс эхлэн
2025 оны 12 -р сарын 31 өдрийг дуустал хүчин төгөлдөр үйлчилнэ.

ДӨРӨВ. ТАТВАРЫН ХЭЛТСИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Татварын хууль тогтоомжид заасны дагуу татварын байцаагч нь сар бүрийн 25-ны дотор гэрээнд заасан үнийн дүнгээр хог хаягдлын хураамжийг хураан авах эрхтэй.

4.2 Гэрээнд зааснаар үйлчлүүлэгч нь гэрээний үүргийг биелүүлээгүй болон биелүүлэхээс татгалзсан тохиолдолд татварын алба нь Татварын ерөнхий хуулийн

55 дугаар зүйлээс 73 дугаар зүйлд заасан процесс ажиллагааг хийх эрхтэй.

4.3 Аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр тээвэрлэгч байгууллагатай тооцоо нийлж байх үүрэгтэй.

4.4 Татварын байцаагч нь аж ахуй нэгж байгууллага бүрээс хог хаягдлын хураамжийг тогтсон хугацаанд, тогтмол хурааж тээвэрлэгч байгууллагын ажилт хийх боломжийг хангах үүрэгтэй.

4.5 Аж ахуй нэгжээс нэхэмжлэлээр хураасан хог хаягдлын хураамжийн задаргааг тээвэрлэгч байгууллагад дараа сарын 3-ны дотор аж ахуй нэгж, байгууллага гаргаж өгөх.

ТАВ. ТЭЭВЭРЛЭГЧ БАЙГУУЛЛАГЫН ЭРХ, ҮҮРЭГ

5.1 Тээвэрлэлт хийсэн аж ахуй нэгж, байгууллагын авлага, өглөгийн мэдээг 7 хоног бүрийн 3 дахь өдөр Татварын хэлтэстэй тооцоо нийлж байх үүрэгтэй.

5.2 Гэрээний үнийн дүн болон ачуулж байгаа хог, тээвэрлэлтийн зардал бодит байдал дээрээ хоорондоо нийцэхгүй тохиолдолд тээвэрлэгч байгууллагаас татварын хэлтэст ИТХ-ийн 10/01 дугаар тогтоолд заасан тарифын дагуу үнийн санал гаргаж гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.

5.3 Үйлчлүүлэгчийн хог хаягдлыг тээвэрлээгүйтэй холбоотой гомдол гаргавал тооцоо нийлж, протокол үйлдэж, тээвэрлэлтийн баримтаар нотлогдоогүй бол хохирлыг тээвэрлэгч байгууллага барагдуулах үүрэгтэй.

5.4 Хог хаягдлын ачилт хийсэн хуудас, нэхэмжлэлийг сар бүрийн 20-ны дотор Татварын хэлтэс өгч, ачилт хийсэн аж ахуй нэгж, иргэн, албан байгууллагын мэдээллийг гаргаж өгөх үүрэгтэй.

5.5 Тээвэрлэгч байгууллага нь Татварын хэлтэстэй тооцоо нийлсний үндсэн дээр хог хаягдлын хураамжаа 3 сараас дээш төлөөгүй иргэн, аж ахуй нэгж, байгууллагын хогийг тээвэрлэхгүй.

ЗУРГАА. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

6.1 Өөрийн гаргасан ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлыг тогтсон хогийн цэгт хаях болон овор хэмжээнээс хамаарч хогны захиалгыг урьд өдөр нь тээвэрлэгч байгууллагын 70000818 дугаарын утсанд ажлын цагаар дуудлага өгнө. Гэрээнд заасан тарифийн дагуу тогтмол рейсийн тоогоор тээвэрлүүлэх.

6.2 Татварын байцаагчаас хог хаягдлын хураамж тушаасан баримт, Тээвэрлэгч байгууллагаас хог хаягдлыг ачуулсан баримтыг шаардан авах эрхтэй.

6.3 Захиалгаар болон тогтсон хуваарийн дагуу очсон тээвэрлэгч авто машиныг хоосон буцаасан, халуун үнс нурамтай, цогтой, хөлдүү хог хаягдал зэргээс шалтгаалж хог ачих, тээвэрлэх, нөхцөл боломжийг бүрдүүлээгүй, тохиолдолд гарсан зардлыг тухайн аж ахуй нэгж байгууллага болон иргэн өөрөө хариуцна.

6.4 Үйлчлүүлэгч нь тогтсон хугацаанд татварын байцаагчид гэрээний дагуу хог хаягдлын хураамжийг төлж байх, Тээвэрлэгч байгууллагад тогтсон хугацаанд, зориулалтын цэгээс, уут саванд хийсэн хог хаягдлыг саадгүй ачуулах үүрэгтэй.

6.5 Ажиллагаагүй гэсэн шалтгаанаар хог хаягдлын хураамж төлөөгүй аж ахуй нэгж, иргэн, албан байгууллага тухайн харьяалагдах хорооноос ажиллагаагүй гэсэн албан бичиг авч баримтжуулах үүрэгтэй.

6.6 Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.2.2-т заасны дагуу шаардлага хангасан зориулалтын хогийн савтай байх үүрэгтэй.

ДОЛОО. ТӨЛБӨР ТООЦОО

7.1 Эрх зүйн баримт бичиг болон стандартад өөрчлөлт орсон тухайн цаг үед гэрээ байгуулсан талуудаас санал оруулах нь нээлттэй.

7.2 Үйлчлүүлэгч /1рейсийн/ үйлчилгээний хураамжийг Дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2022 оны 10/01 дугаар тогтоолоор тогтоосон тарифын дагуу /сар бүрийн.....төгрөг/, /улиралд.....төгрөг/, /жилд.....төгрөг/, /захиалгаар 180.000.....төгрөг/ төлбөрийг төлнө.

7.3 Татвар төлөгч нь хог хаягдлын үйлчилгээний хураамжийг төлбөрийн даалгаврыг үүсгэн банкинд төлнө.

7.4 Татварын хэлтэс нь хураасан мөнгөн дүн болон төлбөр өгсөн аж ахуй нэгж, байгууллагын нэрсийг сар бүрийн 05-ны дотор гаргаж, тооцоо нийлсэн актаар баталгаажуулах үүрэгтэй.

7.5 Хүний гараар ачих боломжгүй, тусгай техник хэрэгсэл ашиглах шаардлагатай хогийг тээвэрлэгч байгууллагаас тусгай машин, техник гаргаж ачуулсан тохиолдолд гарах зардлыг хариуцсан этгээдээр нэмж гаргуулна.

НАЙМ. ГЭРЭЭ ЗӨРЧИГЧИД ХҮЛЭЭЛГЭХ ХАРИУЦЛАГА

8.1 Энэхүү гэрээтэй холбоотой гарсан маргааныг харилцан тохиролцох бөгөөд шийдвэрлэж чадахгүй нөхцөлд холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлүүлнэ.

8.2 Гэрээний биелэлт дээр татварын хэлтэс, тээвэрлэгч, үйлчлүүлэгч байгууллагууд харилцан хяналт тавьж ажиллана.

8.3 Үйлчлүүлэгч автомашинд сул зогсолт үүсгэж, буцаасан тохиолдолд хураамжийн үнийн 50 хувийг тээвэрлэгчид төлөх үүрэгтэй.

8.4 Энэхүү гэрээний 4.4-д заасныг хэрэгжүүлээгүй тохиолдолд иргэн, аж ахуй нэгж, байгууллагын үйл ажиллагаа явуулах тусгай зөвшөөрлийг хүчингүй болгуулах, Хог хаягдлын тухай хуулийн 43 дугаар зүйлд заасны дагуу арга хэмжээг авна.

8.5 Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг хугацаандаа төлөөгүй тохиолдолд хугацаа хэтэрсэн хоног тутамд 0,5 хувиар алданги тооцно.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

Сонгинохайрхан "Тохжилт цэвэрлэгээ үйлчилгээний төв ОНӨААТҮГ" төлөөлж:
Албан тушаал: Хуулийн зөвлөх
Нэр: Ж.Амарсанаа
Гарын үсэг /...../

Аж ахуй нэгж, байгууллагыг төлөөлж:
Албан тушаал:
Нэр:
Гарын үсэг /...../
Утас: 30098742
Хаяг: ЦЭД 207 2000

Уулзалтын 18135
Төлбөрийг гал 59 төсөм

Зураг 17. Хог хаягдалын гэрээ

8. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

Хөрс хамгаалах, цөлжилтөөс сэргийлэх тухай хуулийн 7.2.4-д заасны дагуу эзэмшлийн болон өмчлөлийн газрын 20 хувиас доошгүй талбайд мод тарих, зүлэгжүүлэх шаардлагыг хэрэгжүүлсэн. Үүний хүрээнд нөхөн сэргээлтийн ажлыг төлөвлөж, холбогдох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн.



Зураг 18. Үйлдвэрийн хашаанд мод тарилт

